

Газар хөдлөлтөнд нэрвэгдсэн иргэдэд

0. Хоргодох байр “хинанжёо” руу явах

- Гэртээ байх боломжгүй бол, хоргодох байр руу явна.

Цахилгаан, газ, ус тасарч, 00 хэрэглэх боломжгүй болсон гэх мэт гэртээ байх боломжгүй бол, гэрийнхээ ойролцоох хоргодох байр руу яваарай. Хоргодох байранд, үнэгүй байрлах боломжтой бөгөөд хоол хүнс нь үнэгүй. Мөн, ямар тусламж авах боломжтой талаарх мэдээлэл бий.

1. Хохирлын нөхцөл байдлын зургийг авах

- Хохирлын нөхцөл байдлын талаар тэмдэглэж үлдээх хэрэгтэй.

Засаж янзлахаасаа өмнө, гамшгийн нөхцөл байдал ойлгогдохоор, гэрийнхээ эргэн тойрон болон гэр доторх зургийг авч үлдээгээрэй.

Зөвхөн, орон байрны эвдрэл төдийгүй, эвдэрч хэмхэрсэн эд зүйлс (ж/нь: дугуй, хөргөгч зэрэг цахилгаан хэрэгсэл гэх мэт) -ийн зургийг ч мөн авна.



Усанд автсан тохиолдолд, усны түвшин аль хүрснийг мэдэгдэхээр зургийг нь авна.

Ингэж зураг авч, тэмдэглэж үлдээх нь, дараа нь даатгалаас мөнгө нэхэмжлэх, Гамшгийн хохирогчийн тодорхойлолт “рисай шёомэйшо” авах зэрэгт хэрэг болно.

※ Гамшгийн хохирогчийн тодорхойлолт “рисай шёомэйшо” гэж юу вэ?

Хотын захиргаанд, орон байрны хохирол амссан гэдгээ бичгээр мэдүүлнэ.

Хотын захиргаанд, мэдүүлсэн бичиг баримтанд үндэслэж, хохиролын хэмжээг тогтоох судалгаа хийгдэнэ.

Гамшгийн хохирогчийн тодорхойлолт авсан бол, орон байраа засварлах, дахин босгоход шаардлагатай мөнгөн дэмжлэг, санхүүжилт авах, мөн татвар болон хэрэглээний зардлаас хөнгөлүүлэх, түр орон сууцанд нүүж орох гэх мэт, хохиролын хэмжээнээс шалтгаалан хэрэгтэй тусламж дэмжлэг авахад хэрэг болно. Гамшгийн хохирогчийн тодорхойлолттой бол, оршин суугчийн үнэмлэх “зайру карт” ч дахин авах боломжтой.

Гамшгийн хохирогчийн тодорхойлолтыг мэдүүлснээс хойш бэлэн болох хүртэл, 7 хоногоос 1 сар хүртэл хугацаа зарцуулах тохиолдол бий тул, хотын захиргаанаас лавлана уу.

(Жич:) Бичгээр мэдүүлээгүй тохиолдолд, Гамшгийн хохирогчийн тодорхойлолт авах боломжгүй. Гамшгийн улмаас хохирол амссан бол, хотын захиргаандаа хандана уу.

2. Цэвэрлэхийн өмнө

- Цахилгаан

Цахилгааны гэмтэл гарсан байж болзошгүй тул, цахилгаан унтраагуураа (пускатель) шалгана уу. Пускателийн товч ассан үед масслаж, тогонд цохиулах аюултай тул, гэрээ хийсэн цахилгааны компаниадаа хандаж, зөвлөгөө аваарай.



• Газ

Гэрт чинь хэрвээ газ үнэртвэл, гэрээ хийсэн газын компани руу холбогдож хэлээрэй.

Хотын газ “тоши газу” бол, байгалийн гамшгийн үед, хийн хамгамжийг автоматаар хаадаг. Газ буцаж ажиллаж эхлэсний дараа, “тоолуурын буцах товч”-ийг дарж, газраа ажиллуулна.

Хотын газ “тоши газу”-ыг дахин ашиглаж эхлэхэд, аюулгүй эсэхийг (гэрээ хийсэн) газын компаниасаа лавлаарай.

Пропан газ ашигладаг бол, хийн баллоноос газ алдагдаж байгаа байж болзошгүй тул, (гэрээ хийсэн) газын компани руу холбогдож хэлнэ үү.

• Даатгалын компанитай холбогдох

Гамшгийн даатгал болон орон сууцны эрсдэлийн даатгалд (“татемоно киосай”) хамрагдсан ба, газар хөдлөлтөнд хохирол амссан бол даатгалын компани руугаа холбогдоорой. Засвар гэх мэтэд нөхөн төлбөр авах боломжтой тохиолдол ч гардаг.

Орон сууцанд амьдардаг бол, байрны эзэнтэйгээ холбогдож асууна уу.

Орон гэрээ засварлахаасаа өмнө, хохиролын нөхцөл байдал ойлгогдож харагдахаар зураг авч, даатгалын компани, байрны эзэн, эсвэл уг байр байшинг барьсан барилгын компани руу холбогдож хэлнэ.



3. Цэвэрлэгээ хийх үед анхаарах зүйлс

• Бэртэж гэмтэхгүй байхад анхаарна уу.

Гэмтэж бэртэхээс сэргийлж, түрийтэй гутал, бээлий өмсөөрэй. Тоосжилт, хөгц их үүссэн байгаа тул, халдвар харшлаас сэргийлж заавал маск зүүгээрэй.

Амаа зайлж, гараа угааж, гараа ариутгаарай. Шингэн юм ойр ойрхон уугаарай.

• Хог хаяхдаа, энгийн үеийнхээс өөр гэдгийг анхаараарай.

Дугуй болон хөргөгч зэрэг цахилгаан хэрэгсэл гэх мэт хог хаягдал ихээр гарах тул, энгийн үеийнхтэй адилхан хогийн цэгт хог хаяж болохгүй.

Хотын захиргаа болон айл хөршөөсөө хог хаях газар болон өдөр, цагийг асууж лавлаарай.

• Сайн дурынхны тусламжийг аваарай.

“Гамшгийн үеийн сайн дурын төв”-д олон хүн сайн дурын ажил хийхээр бүртгүүлсэн байдаг. Гэрээ засаж, цэвэрлэж, янзлахдаа, зөвхөн өөрсдөө хийх биш, сайн дурынхны тусламжийг аваарай.

“Гамшгийн үеийн сайн дурын төв” болон нийгмийн халамжийн зөвлөл, хотын захиргаанд хандаж, асууж зөвлөөрэй. Тэд танд үнэ төлбөргүй туслах болно.



сайн дурынхны тусламжийг аваарай.



(Анхааруулга)

• Хулгай болон залилангийн хохирогч болохгүйн тулд анхаарна уу.

Олон нийтийн сүлжээн дэхь мэдээлэлд, ор үндэслэлгүй буруу, худал мэдээлэл ч байдгийг анхаарна уу.

Ямар нэг эргэлзээ төрүүлсэн зүйл гарвал, заавал хэн нэгэн хүнтэй зөвлөнө үү.

• Гадаад иргэний үнэмлэх болон паспортоо хаяж үрэгдүүлсэн бол

Өөрийн улсын Элчин Сайдын Яаманд болон Япон улсын Хилийн шалган нэвтрүүлэх, оршин суух хяналтын газарт (“нюүкан”) мэдэгдэж, холбоо барина уу.